

УВС АЙМАГТ 7 САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

“Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх арга хэмжээг зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу төрийн захиргааны зарим албан хаагчдад зэрэг дэв олгож, үнэмлэхийг гардуулан өглөө. Төрийн албаны салбар зөвлөлд төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв оруулахаар 132 албан хаагчийг өргөн мэдүүлснээс хууль журмын шаардлага хангаж буй 99 албан хаагчдад аймгийн Засаг даргын захирамжаар зэрэг дэвийг шинээр болон ахиулан олголоо.

Архивын ерөнхий газраас 4 жил тутамд Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг орон даяар зохион байгуулдаг. Улсын үзлэгийн хүрээнд аймгийн салбар комиссын бүрэлдэхүүн 2019.07.01-нээс эхлэн аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагууд болон сумдад урьдчилсан үзлэгийг зохион байгуулж, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Увс аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран, Аймаг орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд залуучуудын саналыг авах, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг сонсох, ярилцах шийдвэр гаргагчдад хүргэх зорилго бүхий “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО” зөвлөлдөх уулзалтыг Улаангом хотноо зохион байгууллаа.

Тэс омгийн адууг үүлдэр болгон баталгаажуулах зорилтын хүрээнд уг адуунд явуулсан үржил селекцийн ажлын үр дүнд хянан магадлагаа хийх ажлыг ХХААЯамнаас ажлын хэсэг аймгийн ХХААГазартай хамтран Тэс, Зүүнговь сумуудын Тэс омгийн адуунд хийлээ. Уг ажлын хүрээнд Тэс омгийн адууны тоо толгой, сүргийн бүтэц, тархалтын судалгаа болон бусад холбогдох судалгаанд үнэлэлт дүгнэлт өгөх, адууны хаврын амьдын жин, галбир бие цогцын үндсэн үзүүлэлтүүдийн хэмжилтүүд, хяналтын судалгааг тус тус хийв.

Монгол Улсын маршал, Улсын баатар, Хөдөлмөрийн баатар Юмжаагийн Цэдэнбалын тухай өгүүлэх баримтат, түүхэн “Түүх мартаггүй” уран сайхны киноны зураг авалт Увс аймагт явагдаж байна. Зураг авалт түүний төрсөн нутаг Давст сумаас эхэлж байгаа бөгөөд “Хүмүүн фильм” уран бүтээлийн нэгдлийн уран бүтээлчид болон Увс аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг, "Ойрад" хөгжимт драмын театрын жүжигчид, инженер техникийн ажилчдаас бүрдсэн 200 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Увс аймгийн Өмнөговь суманд ажиллаж байна. Тэрээр Өмнөговь сумын төвийн иргэдтэй уулзаж Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, улс орны эдийн засгийн нөхцөл байдал, аймгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын талаар танилцуулж санал хүсэлтийг нь сонслоо. Иргэд Үндсэн хуулийн өөрчлөлтийн гол заалтуудыг дэмжихээ илэрхийлж байгаа ч УИХ-ын гишүүдийн тоог нэмэх, сонгуулийн жилийг уртасгах асуудал дээр болгоомжтой хандаж мөн орон нутгийн онцлогоо анхаарахыг сануулж байлаа.

Улсын төсвийн 500 сая төргөгийн хөрөнгө оруулалтаар “Увс - АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэсэн “Дэглий цагаан нисэх онгоцны буудал”-ын явгалах замын өргөтгөлийн ажилд Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авлаа.

Явгалах замын өргөтгөл хийгдсэнээр уг нисэх онгоцны буудлын хүчин чадал илүү сайжирч дунд оврын агаарын хөлөг, тийрэлттэй хөдөлгүүртэй агаарын хөлөг хүлээн авах боломжтой болж байна.

Аймгийн ЗДТГ